




Э-Сонин

21 дэх дугаар



2014 он • 1 сар



“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Х.Алтай, дэд захирал Г.Саруул нар өөрсдийн хүсэлтээр ажлаасаа чөлөөлөгдлөө



Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан шийдвэрүүд



ТӨХ-ноос “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчээр Д.Болормааг томиллоо



“Мерекс” ХК-ийн нийтэд санал болгон гаргах хувьцааг үнэт цаасны бүртгэлд бүртгэлээ

“Хай би ойл” ХК-ийн богино хугацаат өглөгийг энгийн хувьцаанд хөрвүүлнэ



Шарын голын уурхайн нүүрсээр утаагүй шахмал түлш үйлдвэрлэнэ

“Женко тур бюро” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд



Үйл явдал

- Монголын Хөрөнгийн Бирж 2013 онд
- Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэрүүд
- “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Х.Алтай, дэд захирал Г.Саруул нар өөрсдийн хүсэлтээр ажлаасаа чөлөөлөгдлөө
- ТӨХ-ноос “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчээр Д.Болормааг томиллоо
- “Хай би ойл” ХК-ийн богино хугацаат өглөгийг энгийн хувьцаанд хөрвүүлнэ
- “Мерекс” ХК-ийн нийтэд санал болгон гаргах хувьцааг үнэт цаасны бүртгэлд бүртгэлээ
- Шарын голын уурхайн нүүрсээр утаагүй шахмал түлш үйлдвэрлэнэ
- “Женко тур бюро” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

- 1-р сарын арилжааны мэдээ

СУРГАЛТ

- Үнэт цаасны зах зээлийн анхан шатны суурь мэдлэг олгох сургалт 3-р сарын 3-ны өдөр эхэлнэ.

Дэлгэрэнгүй мэдээллийг
Утас: 11-313747 /140/
www.mse.mn



**“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ”
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Х.АЛТАЙ, ДЭД ЗАХИРАЛ Г.САРУУЛ
НАР ӨӨРИЙН ХҮСЭЛТЭЭР
АЖЛААСАА ЧӨЛӨӨЛӨГДЛӨӨ**



“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Х.Алтай болон дэд захирал Г.Саруул нь 2014 оны 1 дүгээр сарын 15-ны өдрөөр тасалбар болгон өөрсдийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдлөө.

Х.Алтай, Г.Саруул нар нь 2011 оноос “МХБ” ТӨХК-ийн гүйцэтгэх удирдлагаар ажиллаж эхэлсэн бөгөөд ажиллаж байх хугацаандаа хөрөнгийн зах зээлийг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх ажлын үндэс суурийг тавьж, шат дараатай арга хэмжээг авч хэрэгжүүлсний үндсэн дээр дараах үр дүнд хүрээд байгаа билээ. Тухайлбал:

1. “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-ийг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэн боловсруулж, батлуулах шат, шатны ажлын хэсгүүдэд МХБ-ийн зүгээс голлох үүрэгтэй, ихээхэн ач холбогдол өгч ажилласан. Энэхүү хууль нь 2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлснээр хөрөнгийн зах зээлийн шинэчлэлийн ажлын бодит үр дүн гарч, хөрөнгийн зах зээл олон улсын стандартын дагуу төлөвшин хөгжих, тухайлбал үнэт цаасыг гадаад, дотоодод давхар бүртгэх, кастодианы гэх мэт шинэ үйлчилгээг нэвтрүүлэх, шинэ бүтээгдэхүүнүүд бий болгох нөхцөл бүрдэж байна.
2. Хөрөнгийн зах зээлийн идэвхтэй оролцогчид болох мэргэжлийн хөрөнгө оруулагчдын бүтэц, зохион байгуулалтыг сонгодог утгаар нь бий болгон хөгжүүлэх эрх зүйн орчныг бий болгохоор “Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль”-ийг боловсруулан батлуулах ажлын хэсэгт мөн оролцлоо. Энэ оноос эхлэн хэрэгжиж буй тус хууль нь гадаадын шууд бус хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, үнэт цаасны зах зээлд жирийн иргэдийн оролцох оролцоог нэмэгдүүлэх замаар хөрөнгийн зах зээлийн цаашдын хөгжлийг эрчимжүүлэхэд чухал хувь нэмэр оруулах юм.
3. Шинээр батлагдан гарсан дээрх хуулиудтай нийцүүлэн хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагааг зохицуулах 10 гаруй дүрэм, журмуудыг Санхүүгийн зохицуулах хороотой хамтран шинэчлэн боловсрууллаа.
4. Монгол Улсын Их Хурлын 2009 оны 79 тоот, 2010 оны 11 тоот, Засгийн газрын 2010 оны 86 тоот, 2010 оны 115 тоот тогтоолуудын дагуу Төрийн өмчийн хороо (ТӨХ), Лондонгийн хөрөнгийн бирж групп (ЛХБГ)-ийн хооронд 2010 оны 12 дугаар сарын 24-ний өдөр байгуулагдсан “Стратегийн хамтын ажиллагааны гэрээ”, мөн ТӨХ, “МХБ” ТӨХК болон ЛХБГ нарын хооронд 2011 оны 4 дүгээр сарын 07-ны өдөр байгуулагдсан “Ажлын мастер гэрээ”-ний хүрээнд дотоодын хөрөнгийн зах зээлийг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх их ажлын гарааг эхлүүлж, улмаар “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-ийг амжилттай хэрэгжүүлэхэд гол угтвар нөхцөл болсон хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийг шинэчлэх зорилтынхоо хүрээнд үнэт цаасны арилжаа, төлбөр тооцоо, хяналтын цогц шийдэл бүхий “Миллениум Ай Ти” системийг 2012 оны 7 дугаар сарын 02-ны өдрөөс Монголын хөрөнгийн зах зээлд амжилттай нэвтрүүллээ. Түүнчлэн, “МХБ” ТӨХК-ийн гишүүн брокер, дилерийн компаниуд тус системийг ашиглан алсаас буюу интернет арилжаа хийх боломжтой болсноор хөгжилд нэг алхмаар ойртсон явдал болсон.
5. Үнэт цаасны арилжааны төлбөр тооцоог урьдчилсан төлбөрт системээс дараа төлбөрт Т+3 системд шилжүүлж, эрсдлийн удирдлагын цоо шинэ механизмыг зах зээлийн бусад оролцогчдын хамт бий болгов. Ийнхүү төлбөр тооцооны олон улсын стандарттай болох нь хөрөнгө оруулалтын чирэгдэл, үргүй зардлыг багасгах, олон улсын хөрөнгө оруулагчид зах зээлд нэвтрэх таатай нөхцөлийг бий болгож байгаа юм.

6. Олон улсын хэмжээнд хөрөнгийн зах зээлийн индексийн тооцоо, судалгааны чиглэлээр тэргүүлэгч Их Британийн FTSE групптэй санхүүгийн индекс боловсруулан тооцоолох чиглэлээр хамтран ажиллах гэрээг байгууллаа. Түүнчлэн, Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг “Хөгжиж буй” (Фронтинер) зах зээлийн ажиглалтын жагсаалтад багтааж, олон улсын статус зэрэглэлгүй байсан Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг ийнхүү статустай болгох боломж нээгдсэнээр Монголын хөрөнгийн зах зээлд оролцох гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх, улмаар арилжааны эргэлт, зах зээлийн хөрвөх чадварыг сайжруулах, “МХБ” ТӨХК-ийн үйл ажиллагааг олон улсын түвшинд нэг алхмаар ойртуулах чухал ач холбогдолтой арга хэмжээ болох юм.

7. Дотоодын хөрөнгийн зах зээлийн шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлэх гол хүчин зүйлийн нэг болох боловсон хүчний мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Лондонгийн хөрөнгийн биржийн академийн сургалтанд 120 гаруй мэргэжилтнийг хамруулсны зэрэгцээ хөрөнгийн зах зээлийн шинэ технологи, шинэ бүтэц тогтолцоог зах зээлийн оролцогчдод тайлбарлан таниулах ажилд голлох үүрэгтэй ажилласан.

8. Хөрөнгийн зах зээлийн нээлттэй, ил тод байдлыг сайжруулах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор “МХБ” ТӨХК нь цахим хуудсаараа дамжуулан бүртгэлтэй хувьцаат компаниудын санхүүгийн тайлан, хувьцаа эзэмшигчдийн хурлын зар, мэдэгдэл, шийдвэрүүдийг цаг алдалгүй хүргэж байгаагийн зэрэгцээ хувьцаат компаниудын засаглалыг сайжруулахад анхааран ажилласны үндсэнд тодорхой үр дүнд хүрээд байна. Тухайлбал, өмнөх онд 97 компани санхүүгийн тайлангаа ирүүлсэн бол 2013 онд 217 болж 2.23 дахин өссөн үзүүлэлттэй байна.

9. Түүний ажилласан жилүүд болох 2011 онд үнэт цаасны арилжааны хэмжээ түүхэндээ хамгийн дээд цэгтээ буюу 113.5 тэрбум төгрөг, 2012 онд 145.0 тэрбум төгрөгт хүрч, Монголын хөрөнгийн зах зээл дэлхийн хамгийн өсөлттэй зах зээлд тооцогдож байсан ч “МХБ” ТӨХК дээрх нийт арилжааны 90 орчим хувийг бүрдүүлдэг гадаадын хөрөнгө оруулалт 2012-2013 онд улсын хэмжээнд 50 гаруй хувиар буурч Монгол улсын эдийн засаг хүндэрсэн, дэлхийн эдийн засаг, санхүүгийн зах зээлд уналтууд бий болсон зэрэгтэй холбоотойгоор 2013 онд 98.6 тэрбум төгрөгийн арилжаа явагдсан байна. Гэвч энэ нь Гүйцэтгэх захирал Х.Алтайг үүрэгт ажилд томилогдохоос өмнөх жилүүд буюу 2008 онтой харьцуулахад даруй 60 орчим хувиар, 2009 онтой харьцуулахад 4 дахин тус тус өссөн байна. Төр засгийн зүгээс гадаадын хөрөнгө оруулалтын урсгалыг сэргээх талаар хийж буй арга хэмжээ зах зээлийн цаашдын үзүүлэлтүүдэд эерэг үр дүн үзүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

10. Зах зээлийн мэдээ мэдээллийг олон нийтэд цаг алдалгүй, шуурхай хүргэж, олон нийтийн зах зээлийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллав. Тухайлбал, үнэт цаасны зах зээлийн суурь мэдлэг олгох сургалтанд сүүлийн жилүүдэд нийт 1500 гаруй иргэд хамрагдсан байна. Хөрөнгө оруулалтын томоохон 3 чуулга уулзалтыг зохион байгуулсны зэрэгцээ хөрөнгө оруулалтын танилцуулга сурталчилгаа роудшоуг 4 хотод нийт 20 гаруй олон улсын хөрөнгө оруулалтын сангуудад хийж, бусад 600 гаруй хөрөнгө оруулагчдыг бирж дээр хүлээн авч, танилцуулга сурталчилгаа хийсэн.

Хөрөнгийн зах зээлийг олон улсын стандартанд нийцүүлэн хөгжүүлэх их зорилгыг хэрэгжүүлэхийн төлөө хүчин чармайлт гарган ажиллаж, цаашдын эрчимтэй өсөлт хөгжлийн үндсийг амжилттай тавьсан Х.Алтай, Г.Саруул нарын цаашдын ажилд нь “МХБ” ТӨХК-ийн нийт ажилтнуудын зүгээс амжилт хүсье.

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн дараагийн Гүйцэтгэх захирлын сонгон шалгаруулалтыг олон нийтэд нээлттэй зарлан явуулах ажлыг Төрийн өмчийн хорооноос зохион байгуулж байгаа бөгөөд сонгон шалгаруулалтын дүн гарах хүртэлх хугацаанд компанийн гүйцэтгэх удирдлагын ажил үүргийг тасалдуулахгүй байх үүргийг Төрийн өмчийн хороо хүлээгээд байна.



12 ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНЭТ ЦААСЫГ БҮРТГЭЛЭЭС ХАСЛАА

Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 500 тоот тогтоол, МХБ-ийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 58, 59.1 дэх хэсгийг үндэслэн "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2014 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 14 тоот тушаалаар дараах нэр бүхий 12 хувьцаат компани, тэдгээрийн үнэт цаасыг МХБ-ийн үнэт цаасны бүртгэлээс хаслаа.

Дээрх компаниуд нь "Үнэт цаасны зах зээлийн тухай" хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3, 10.1.4, 10.1.5 дахь заалтууд, Хөрөнгийн бирж болон Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журмын дагуу хувьцаа эзэмшигчдэд хүргэх ёстой мэдээллийг хуульд заасан хугацаанд хүргээгүй, Хорооноос өгсөн хугацаатай үүрэг, даалгаврыг биелүүлээгүй зэрэг зөрчлүүдийг удаа дараа гаргаж, МХБ-ийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"-аар тогтоосон үнэт цаасны шалгуур

үзүүлэлтийг бүрэн хангаж ажиллаагүй юм. Цаашид эдгээр компаниуд нь хаалттай хувьцаат компани хэлбэрээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх боломжтой.

МХБ-ийн үнэт цаасны бүртгэлээс хасагдсан компанийн нэрс:

1. "Торгон үр" ХК
2. "Дорнод ноос" ХК
3. "Алтай ханын материал" ХК
4. "Дар зам" ХК
5. "Мандал Оргил" ХК
6. "Улбаа" ХК
7. "Сүмбэр-Өлзий" ХК
8. "Тээвэр төв" ХК
9. "Говь сүмбэр" ХК
10. "Улаан хотгор" ХК
11. "Жинчин" ХК
12. "Арилжаа" ХК



"МЕРЕКС" ХК-ИЙН НИЙТЭД САНАЛ БОЛГОН ГАРГАХ ҮНЭТ ЦААСЫГ БҮРТГЭЛЭЭ

Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 514 тоот тогтоолыг үндэслэн Монголын хөрөнгийн бирж "Мерекс" (MSE:MRX) ХК-ийн олон нийтэд санал болгож буй нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 65,005,000 ширхэг хувьцааг Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны жагсаалтад 2014 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн "МХБ ТӨХК"-ийн Гүйцэтгэх захирлын тушаалаар бүртгэлээ.

2012 онд "Мерекс" ХК гадаад худалдаа, барилгын материалын худалдааны чиглэлээр үүсгэн байгуулагдсан. Сонгинохайрхан дүүрэгт БНСУ-д үйлдвэрлэсэн цагт 150 м.куб бетон үйлдвэрлэх хүчин чадалтай TW-2500 маркийн бетон зуурмагийн үйлдвэр барьж буй юм. Цаашид үйлдвэрлэлийг жигдрүүлж, бизнес төлөвлөгөөгөө бүрэн хэрэгжүүлж, компани үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхээр 2.6 тэрбум төгрөгийг зах зээлээс татан төвлөрүүлэх буюу компанийн нийт хувьцааны 40% болох 26,000,000 ширхэг энгийн хувьцааг олон нийтэд санал болгох ажээ.

Тус компанийн андеррайтераар "Стандарт инвестмент" ХХК ажиллаж байна.

Үнэт цаасны нэрлэсэн үнэ:	100 төгрөг
Олон нийтэд санал болгох үнэт цаасны тоо:	26,000,000 ширхэг
Олон нийтэд санал болгох хувь:	40%
Олон нийтэд санал болгох үнэ:	100 төгрөг
Олон нийтэд санал болгох арга:	Тогтоосон үнийн арга
Үнэт цаасны захиалга авах өдөр:	2014 оны 3 дугаар сарын 3-наас

"www.standardinvestment.mn"




**ТӨХ-НООС “МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧЭЭР
Д.БОЛОРМААГ ТОМИЛОО**

“Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 11 дүгээр зүйлийн 9, 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8, Гүйцэтгэх захирал Х.Алтайн “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн (МХБ) төлөөлөн удирдах зөвлөлийн даргад гаргасан ажлаас чөлөөлөгдөх хүсэлт зэргийг үндэслэн Төрийн өмчийн хороо, МХБ-ийн ТУЗ-ийн 2014 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 01 тоот тогтоолоор МХБ-ийн Гүйцэтгэх захирал Х.Алтайг 2014 оны 1 дүгээр сарын 15-ны өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас чөлөөлж, гүйцэтгэх захирлын сонгон

шалгаруулалтын үр дүн гарах хүртэлх хугацаанд компанийн гүйцэтгэх удирдлагын ажил үүргийг тасалдуулахгүй байх арга хэмжээ авч ажиллахаар Төрийн өмчийн хорооны Төрийн удирдлагын газрын дарга Д.Болормааг МХБ-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томиллоо.

Төрийн өмчийн хороо Ажлын хэсэг байгуулан Х.Алтайн ажлыг хүлээн авсан бөгөөд Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирлыг сонгон шалгаруулах ажлыг олон нийтэд нээлттэй зарлаж зохион байгуулах юм.

ЖЕНКО ТУР БЮРО ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРЛД



“ЖЕНКО ТУР БЮРО” (MSE:JTB) ХК-ийн ТУЗ-өөс хувьцаа эзэмшигчиддээ “ҮЦТТТХТ” ТӨХХК-иар дамжуулан ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн ч тус байгууллагын гаргасан шинэ журмаар тогтоосон үйлчилгээний тарифаар үйлчилгээ авах боломжгүй болсон тул хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгаа компанийн өөрийн байрнаас тараахаар тогтжээ.

Ногдол ашиг тараалтын дэлгэрэнгүй мэдээллийг **энд дарж** үзнэ үү.

**“ХОРОЛ-ЭРДЭНЭ” ХК -ИЙН ҮНЭТ ЦААСЫГ МХБ-ИЙН ҮНЭТ
ЦААСНЫ БҮРТГЭЛЭЭС ХАСЛАА**

СЗХ-ны 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 546 тоот тогтоол, Монголын хөрөнгийн биржийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 58, 59.1-р заалт, “Хорол-Эрдэнэ” ХК-ийн 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 57/2013 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу хийсэн шалгалтын тайланг тус тус үндэслэн МХБ-ийн гүйцэтгэх захирлын 2014 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 23 тоот тушаалаар “Хорол-Эрдэнэ” ХК-ийн гаргасан нийт 86,850 ширхэг хувьцааг Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны бүртгэлээс хаслаа.



“ХАЙ БИ ОЙЛ” ХК-ИЙН БОГИНО ХУГАЦААТ ӨГЛӨГИЙГ ЭНГИЙН ХУВЬЦААНД ХӨРВҮҮЛНЭ

Хай Би Ойл (MSE:HBO) эзэмшдэг ажээ. ХК-ийн 2013 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралдаанаар богино хугацаат хөрвөх зээлийг компанийн энгийн хувьцаанд шилжүүлэх тухай асуудлыг хэлэлцэж ТУЗ-өөс шийдвэрлэсэн. Энэхүү богино хугацаат зээл нь БНАСАУ-ын төрийн өмчит КОЕСII компанийн 20%-г эзэмшдэг Малайз улсад бүртгэлтэй Ninox Hydrocarbons (L) Berhad (Одоо HBOil (L) Berhad болсон) компанийг 100% эзэмших болсонтой холбоотой юм. КОЕСII компанийн 80%-ийг БНАСАУ-ын газрын тосны үндэсний хайгуулын компани болох КОЕС (“Korean Oil Exploration Corporation”) эзэмшдэг ажээ. Мөн Хай Би Ойл ХК нь Сингапур улсад бүртгэлтэй Ninox Energy компанийн 12%-г эзэмших болсон бөгөөд тус Ninox Energy компани нь БНАСАУ-ын Зүүн тэнгисийн ойлборлолтын бүтээгдэхүүн хуваах гэрээтэй (“БХГ”) Korex компанийг 100% эзэмшдэг юм. Хай Би Ойл ХК нь Ninox Energy компанитай урьд нь байгуулсан хөрвөх зээлийн гэрээний дагуу тус компанийн 12%-тай тэнцэх хувьцааг хөрвүүлж ингэснээр Хай Би Ойл ХК-ийн хувьцаа эзэмшигчид шууд бус байдлаар Зүүн тэнгисийн газрын тосны боломжит нөөцтэй талбайд хувь эзэмших юм.



ШАРЫН ГОЛЫН УУРХАЙН НҮҮРСЭЭР УТААГҮЙ ШАХМАЛ ТҮЛШ ҮЙЛДВЭРЛЭНЭ

“Шарын гол” ХК-ийн удирдлага нүүрс баяжуулах үйлдвэр барих, утаагүй түлш-брикетийн үйлдвэрээ өргөтгөх ажилд зориулан ЕСБХБ-аас 10,0 сая ам.долларын санхүүгийн багц зээл авах гэрээнд гарын үсэг зурсан байна.

Тус зээлээр нүүрсний байгалийн болон механик чулуу хольцыг ялгах, ангижруулж, боловсруулах үйлдвэр барьж мөн шахмал түлшний үйлдвэрийнхээ хүчин чадлыг нэмэгдүүлэх боломж бий болох юм.

Угаасан нүүрс болон брикетэн түлш нь үйлдвэрээс эцсийн хэрэглэгчдэд буюу хайлуулах, цементийн үйлдвэрүүд болон

айл өрхийн хэрэгцээнд очих юм. Европын сэргээн босголт, хөгжлийн банкны Байгалийн баялгийн асуудал хариуцсан захирал Эрик Расмуссен: “Бид Улаанбаатар хотын агаарын чанарыг сайжруулах төсөл дээр “Шарын гол” ХК-тай хамтран ажиллах болсондоо ихээхэн баяртай байна. Орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжилд нааштай нөлөө үзүүлэхийн төлөө зүтгэж буй компанийн хариуцлагыг өндрөөр үнэлж байна. Өндөр чанартай цэвэр, өртөг шингэсэн нүүрсний үйлдвэрлэлийн талаарх компанийн стратегийг бид дэмжихэд бэлэн байна” хэмээжээ.



Сарын арилжааны мэдээ

2014 оны 01 дүгээр сар

Арилжааны товч мэдээ	
Арилжигдсан ширхэг	1,642,134
Нийт үнийн дүн	917,775,784.76
Хэлцлийн тоо	1,674
Арилжигдсан үнэт цаасны тоо	92
Зах зээлийн үнэлгээ	1,623,963,751,640

ТОП-20 индекс	
Хаалт	16,011.96
Өмнөх сарын хаалт	16,301.81
Өөрчлөлт /нэгж/	-289.85
Өөрчлөлт /%/	-1.78
52 долоо хоног дээд	18,301.93
доод	13,188.46

Идэвхтэй арилжигдсан үнэт цаас:									
Тоо ширхгээр:					Үнийн дүнгээр:				
№	Симбол	Үнэт цаасны нэр	Арилжсан ширхэг	Үнийн дүн	№	Симбол	Үнэт цаасны нэр	Арилжсан ширхэг	Үнийн дүн
1	ETR	Э- ТРАНС ЛОЖ ИСТИК	422,767	49,460,999	1	APU	АПУ	29,307	118,238,383
2	ЛТВ	Ж ЕНКО ТУР БЮРО	284,496	24,481,826	2	DAR	ДАРХАН ГУРИЛТЭЖЭЭЛ	145,931	87,563,100
3	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	227,068	37,375,954	3	TTL	ТАВАН ТОЛГОЙ	14,460	77,170,793
4	DAR	ДАРХАН ГУРИЛТЭЖЭЭЛ	145,931	87,563,100	4	ВУК	УБ БУК	1,731	68,329,100
5	RMC	РЕМИКОН	139,869	21,872,963	5	ТЕЕ	ТЭЭВЭР ДАРХАН	2,650	66,250,000

Хамгийн их өсөлттэй үнэт цаас:								
№	Симбол	Үнэт цаасны нэр	Өмнөх сарын хаалт	Хаалтын ханш	Ханшийн өөрчлөлт			
					төгрөг	хувь		
1	UNS	УЛААН САН	340.00	784.76	445	130.81		
2	ALI	АРИЛЖАА ИМПЕКС	200.00	454.73	255	127.37		
3	DLH	СЭЛЭНГЭ ДУЛААНХААН	100.00	174.89	75	74.89		
4	ННС	БИШРЭЛТ ИНДАСТРИЛ	3,000.00	4,550.00	1,550	51.67		
5	GTJ	ГУРИЛТЭЖЭЭЛБУЛГАН	3,605.00	5,290.00	1,685	46.74		

Хамгийн их бууралттай үнэт цаас:								
№	Симбол	Үнэт цаасны нэр	Өмнөх сарын хаалт	Хаалтын ханш	Ханшийн өөрчлөлт			
					төгрөг	хувь		
1	DAR	ДАРХАН ГУРИЛТЭЖЭЭЛ	770.00	600.00	-170	-22.08		
2	MNH	МОНГОЛ НЭХМЭЛ	6,200.00	5,000.00	-1,200	-19.35		
3	DHU	ДАРХАН ХҮНС	5,200.00	4,300.00	-900	-17.31		
4	HGL	ХАНГАЛ	1,300.00	1,105.00	-195	-15.00		
5	КЕК	МОНГОЛ КЕРАМИК	7,860.00	6,685.00	-1,175	-14.95		